*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ МАЛ АЖ АХУЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГАНБОЛД ОВОГТОЙ ЭНХ-ОЮУНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** МАЛ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, НОРМ НОРМАТИВЫГ СУРТАЛЧЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Малчдыг төрөл бүрийн сургалт, зөвлөгөөнд хамруулж мэдээ мэдээллээр хангах, чадавхыг сайжруулах | Сургалтад хамрагдсан, туршлага судалсан малчдын тоо | 130 | 100 | Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-г улс орон даяар өрнүүлж аймгуудыг бүсчлэн Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлхээр 1 сарын аяны арга хэмжээг 4/26-27ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус арга хэмжээнд хоршооны төлөөлөл 6 иргэн, 4 малчин иргэн оролцсон. Мөн Монголын мал зүйч үржүүлэгчдийн үндэсний холбооноос "Хонины аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн" 06 сарын 08-нд УБ хотод зохион байгуулагдаж 6-р багийн 2 иргэн оролцсон. “Тэгш боломжийн төлөө-залуучуудын манлайлал” аймгийн залуу малчдын туршлага солилцох | 2024.04.01-ээс 2024.12.01 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

110

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалтанд Арвайхээр сумаас 18 залуу малчин 11сарын 13-ны өдөр оролцож, малчдад тулгамдаж буй асуудал, цахим хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар гэх мэт улс, аймгийн сайн малчдаас туршлага судаллаа. Мөн Буянт төв ХХК-иас өөрийн нийлүүлдэг бордоо, Ургамал хамгааллын бодис, төрөл бүрийн таримлын үрийн мэдээлэл солилцох уулзалтыг эрчимжсэн аж ахуй иргэдэд 11сарын 13-ны өдөр зохион байгууллаа. | | |
| 2. | Сум, аймаг, улсын аварга малчин шалгаруулах журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Тухайн ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | - | Улс, аймаг, сумын аварга малчин шалгаруулах журмыг хэрэгжилтийг хангаж ажилласнаар аймгийн аварга малчин өрх 6, аварга фермер 1, аймгийн аварга тариаланч 1, сумын аварга малчин , аварга саальчин 1 шалгарч, нийт аваргуудын шагналын эд зүйлсийг бэлтгэн, хуваарийн дагуу шагналыг гардуулах ажлыг зохион байгуулж ажиллав. | 2024.01.01-ээс 2024.03.01 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 3. | Малчин өрхийн гэрчилгээ, баталгааны тамга, мэргэжлийн үнэмлэх, тэмдгийн захиалга авч холбогдох байгууллагад хүргүүлэх, малчдад үнэмлэх, тэмдэг, гэрчилгээ олгох | Тухайн ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 50 | Малчин өрх ноос, ноолуур, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэлд баталгааны тэмдгийг дарж баталгаажуулах ажлыг хэвшүүлээд байна. Тайлант хугацаанд баталгааны тэмдэгтэй болох 15 малчнаас хүсэлт ирсний дагуу тэмдгийг Монгол тамга урлал тамганы үйлдвэрт захиалж, олгосон. | 2024.01.01-ээс 2024.11.01 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 4. | "Малын индексжүүлсэн даатгал"-д нийт малчин өрхийн 15-аас доошгүй хувийг хамруулах ажлыг зохион байгуулах | Даатгалд хамрагдсан малчин өрхийн эзлэх хувь | 5 хувь | 5 | Нийт 1087 малчин өрхөөс 2024 оны хагас жилийн байдлаар 20 малчин өрх 7596 толгой малыг 3138000 мян төгрөгөөр даатгал хийлгэсэн. | 2024.01.01-ээс 2024.06.01 хүртэл | Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь |
| 5. | Малын тоо толгойн | Малын тоо | 0 | 0 | 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн | 2024.01.01- | Тодорхой |

171

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан татварын орлогоос малын чанар сайжруулах, биотехнологийн дэвшилтэт арга технологийг ашиглан зохиомол хээлтүүлэг хийх ажилд хөрөнгө оруулалт хийх (хамтран ажиллах гэрээ) | толгойн албан татвараас малын чанарыг сайжруулах ажилд зарцуулсан төсвийн дүнгээр | | | төлөвлөгөөний дагуу Малын тоо толгойн албан татварын орлогоос бэлчээрийн менежментийг сайжруулахад 20,0сая, малын чанарыг сайжруулахад 10,0сая төгрөг зарцуулахаар тус тус төлөвлөсөн. Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажлуудыг зохион байгуулсан. Мал амьтанд үзлэг, оношилгоо хийх зөөврийн өнгөт эхо аппарат 18,0сая төгрөгөөр Атар-ирээдүй ХХК нийлүүлсэн. Мөн бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Уртын эх, Дарштын амны худгуудын байр барих, засварлах ажлуудыг 4,9сая төгрөгийн төсөвт өртгөөр, малын эрүүл мэндийг сайжруулах ажилд 25,8сая төгрөг, бэлчээрийн менежмент сайжруулах ажилд 10,6сая төгрөг, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд 28,3сая төгрөг, буюу нийт 74,380,000төгрөг зарцуулсан байна. | ээс 2024.12.01 хүртэл | үр дүнд хүрсэн 70 хувь |
| 6. | Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангаж ажиллах | 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан хувь | 100 | - | Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээ”-ний тухай 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/635 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 2024 оны А/151 дугаар захирамж гарсан. Захирамжаар төв суурингийн, хөдөө аж ахуйн өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах 2 ажлын хэсгийг баталсан. Аймгийн Засаг даргын албан | 2024.08.01-ээс 2024.11.30 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

172

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даалгаварын хүрээнд сумын аюулгүй нөөцөд 37,5тн өвс, 12,5тн тэжээл, малчдын түвшинд бэлтгэх өвс 1250тн, гар тэжээл 415тн, хужир шүү 840тн–ыг бэлтгээд байна. Сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүний явцын мэдээг ХХААГазарт мэдээлж ажилласан. 2024 онд Арвайхээр сумын 295,0 мян мал өөрийн аймгийн бусад сумдад өвөлжих тооцоо гарч бэлтгэл ажил 85 хувьтай байна. | | |
| 7. | Өвөлжөө, хаваржааны 0.7 га газрын дэргэд 1000м$^2$ газарт малын тэжээлийн ургамал тариалах ажлыг дэмжих | Тэжээлийн ургамал тариалсан өрхийн тоо | 5 | - | Аймгийн Хөдөө аж ахуйн газраас малчдын өвөлжөө, хаваржааны хөлд малын ногоон тэжээл тариалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор овъёосны үрийг хямдралтай үнээр олгосон бөгөөд 25 малчин өрх малын хашаа хорооны хөлдөө болон тариалангийн талбайд нийт 37.1га–д ногоон тэжээл тариалсан. Малчдын малын тэжээл тариалалт урд онд 31.4га талбайд тариалж байсан бол энэ онд 37.1 га-д тариалж 1,18 хувиар өссөн үзүүлэлттэй байна | 2024.06.01-ээс 2024.09.01 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| **Зорилт 2.** ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ“ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ | | | | | | | |
| 1. | Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, ажлыг зохион байгуулж ажиллах | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 10 аж ахуй нэгж, 153 иргэнийг бүртгэл жүүлж, 4 аж ахуй нэгж, иргэний гарал | 1 | Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-г улс орон даяар өрнүүлж аймгуудыг бүсчлэн арга хэмжээг зохион байгуулж “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлхээр ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд малчдад 6 хувийн хүүтэй, 50 хүртэлх сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг 60 хүртэлх сарын хугацаагаар олгох бөгөөд Арвайхээр | 2024.01.01-ээс 2024.06.01 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үүслийг баталга ажуулж, урамшууллын хүсэлтийг илгээсэн | | суманд 6 малчны хоршоо шинээр байгуулагдан арилжааны банкуудад зээлийн хүсэлтээ гарсан байна. Мөн энэ онд сумын хоршоо хөгжүүлэх сангаас арьс шир боловсруулах чиглэлээр 1 хоршоонд 85,0сая төгрөгийн зээл олгосон. | | |
| 2. | Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх | Туршлага судалсан, сургалтад хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч малчдын тоо | 4 | - | Монголын мал зүйч үржүүлэгчдийн үндэсний холбооноос "Хонины Аж Ахуй Эрхлэгчдийн Зөвлөгөөн" 06 сарын 08-нд УБ хотод зохион байгуулагдаж 6-р багийн 2 иргэн оролцсон.<br>Малыг богино хугацаанд чанартай тэжээлээр бордож жин, сүүний гарцыг нэмэгдүүлэх хүчит тэжээл үйлдвэрлэгч Буянт төв ХХК-иас өөрийн нийлүүлдэг бордоо, Ургамал хамгааллын бодис, төрөл бүрийн таримлын үрийн мэдээлэл солилцох уулзалтыг 11 сарын 13-ны өдөр Арвайхээр, Хайрхан дулаан, Баруунбаян улаан сумдын эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэдэд зохион байгуулж иргэдээс үнэлгээ авч цаашид малыг богино хугацаанд бордож өндөр ашигтай ажиллах боломж байгаа гэж үзсэн. | 2024.01.01-ээс 2024.06.08 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| Зорилт 3. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ТОГТВОРЖУУЛАХ, МАЛ, ТҮҮНИЙ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | "Бэлчээрийн малд сүргийн эргэлтийн тооцоолол боловсруулах программ"-д малчин өрхийн мал сүрэгт сүргийн эргэлтийг тооцоолон гаргах, мэдээ | Сүргийн эргэлтийн тооцоолол хийсэн малчин өрхийн тоо | 100 | 30 | Үнэлэх боломжгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр хангаж ажиллах | Эдийн засгийн эргэлтэд оруулсан малын эзлэх хувь | 2 | - | Арвайхээр сум урд оны мал тооллогод 1084 малчин өрх, 422 мал бүхий өрхөд нийт 262608 толгой мал тоолуулсан.<br>Энэ онд 121822 хээлтэгч тоологдсноос 83890 төл мал бойжуулж, нийт 2667 мал зүй бусаар хорогдсон байна.<br>Малчдын дотоодын хэрэгцээнд ашиглах болон зах зээлд борлуулах малын тооцоо судалгааг мал эмнэлгийн гэрчилгээ олгож буй арга хэмжээтэй уялдуулан гаргаж, энэ онд 47мян.толгой мал буюу жилийн эцсийн мал тооллогын дүнтэй харьцуулахад 17.9хувийг Улаанбаатар хот болон орон нутгийнхаа дотоодын хэрэгцээг ханган борлуулж байна. Ард иргэдийн өргөн хэрэгцээний мах, сүү, цагаан идээг малчдын гар дээрээс үнийн хөөрөгдөлгүй авч хэрэглэх, мөн Арвайхээр сумын болон бусад сумдын малчдад мах, сүү цагаан идээгээ борлуулж ашиг олох нөхцөл боломжийг бүрдүүлж Занабазарын цэцэрлэгт хүрээлэнгийн баруун хэсэгт борлуулалтын цэг байгуулж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | 2024.06.01-2024.12.01 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 2. | Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв нэгтгэж, цахимаар буюу файлаар холбогдох байгууллагуудад илгээх | Мэдээний тоогоор | 17 | 11 | Мал төллөлт, төл бойжилтийн мэдээ (ХАА-1) хорогдлын мэдээ ХАА-2 мэдээнүүдийг 3,4,5сарын байдлаар 3 удаа нэгтгэж мэдээ гаргасан. Мөн хөдөө аж ахуйн Малын үндэсний бүртгэл мэдээллийн санд 7 хоног бүр мал төллөлт, хорогдлын мэдээг оруулж байна. Арвайхээр сум урд оны мал тооллогод 1084 малчин өрх, 422 мал бүхий өрхөд нийт 262608 толгой мал | 2024.03.01-ээс 2024.10.08 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоолуулсан.<br>Энэ онд 121822 хээлтэгч тоологдсноос 83890 төл мал бойжуулж, нийт 2667 мал зүй бусаар хорогдсон байна. | | |
| 3. | Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, анги чанарыг тогтоох, ялган тэмдэглэж, мал аж ахуйн нэгдсэн системд хамруулах, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг малчдад нийлүүлэх ажлыг зохион байгуулах | Үзлэг ангилалтад хамрагдсан малын тоогоор | 0 | 30 хувь | Бог малын хээлтүүлэгч оны эхний тоогоор 689 хуц, 564 ухна нийт 1253 хээлтүүлэгч мал байгаа бөгөөд гэрээт малчинд 68 хуц, 27 ухна ялган төвлөрүүлсэн. Өмнөх онд Хас онги технологийн үржлийн нэгжтэй хамтран 8 өрхөд Баяд овгийн хуцийг иргэдэд гэрээгээр эзэмшүүлж байна. | 2024.01.01-2024.04.30 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| | | Ялган тэмдэглэсэн малыг мал аж ахуйн нэгдсэн системд хамруулсан хувь | 0 | 50 хувь | Бод малын 80 ширхэг, бог малын 870 ширхэг ээмэг захиалан авсан бөгөөд бүртгэл мэдээллийг бүрэн хийж дуусаагүй байна.<br>Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн системд ялган тэмдэглэсэн нийт 112 хуц, ухна бүртгэлтэй байна. | 2024.06.01-2024.12.10 | Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь |
| 4. | Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа эрхлэгчдийн үнээг ялган тэмдэглэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг зохион байгуулах. (livestock.mofa.gov.mn) | Ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн үхрийн хувь | | - | Өмнөх онуудад эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн мах сүүний хосолмол ашиг шимт 539 үхэрт ялган тэмдэглэх ажил хийгдсэн бөгөөд малын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд бүртгэлжүүлэх ажлыг 10 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн мэдээллийг оруулах шинэчлэх ажил хийгдэж байна. | 2024.06.01-2024.12.10 | Эрчимжүүлэх шаардлагатай 30 хувь |
| 5. | Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2023 оны жилийн эцсийн малын тоог малчин өрх бүрээр оруулах, баяжилт, тулгалт хийх ажлыг зохион байгуулах | Малчин өрхийн тоогоор | 993 | 1087 | 2023 оны статистикийн малын тоог Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татаж шинэчлэх ажлыг 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулсан бөгөөд 1433 малчны мэдээллийг бүрэн шинэчилж хэрэгжилт 99 хувьтай байна. | 2024.01.01-2024.04.30 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| **Зорилт 4. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |

146

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, хурал болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | Үйл ажиллагааны үр дүнгээр | | | Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 4 зорилтын хүрээнд зохион байгуулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 24 дүгээр хуралдаанаар хэрэгжилт үр дүнг тайлагнахад 94,5 хувийн хэрэгжилттэй хэмээн үнэлэгдсэн. | 2024.01.01-ээс 2024.06.08 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 2. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | | | Аймаг сумын ЗДТГазар болон бусад дээд шатны байгууллагаас 3 албан бичиг ирснээс 1 хариутай албан бичгийн хариуг нь заасан хугацаанд маягтын дагуу үнэн зөв гарган өгч ажилласан. | 2024.01.01-ээс 2024.06.08 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх | | | Шинээр гарсан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамж, аймаг, сумын ИТХурлаас гарсан тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчийн хувьд хариуцсан ажилдаа хариуцлагатай, бүтээлч, шударга ажиллах, иргэнд ил тод тэгш хүртээмжтэй үйлчлэх, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хувийн зохион байгуулалтаа сайжруулах талаар анхааран ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", байгууллагын дотоод журмыг үйл | 2024.01.01-ээс 2024.06.08 хүртэл | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж хэвшсэн. Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийгдээгүй.<br>Улс тунхагласны баярыг угтан 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагаа өргөсөн. | | |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ний биелэлт

| № | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллах | Холбогдох хууль тогтоомжийн дагуу санал гомдолгүй ажилласан эсэх | 2023 онд үнэлгээний хороонд ажиллаагүй. | Сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил | Сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 7 ажил, харьяа төсөвт сургуулийн 1 бүтээгдэхүүн нийлүүлэх тендерт үнэлгээний хорооны гишүүн, нарийн бичгээр ажиллаж, холбогдох цахим болон цаасан бичиг баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу бэлтгэж, гомдол санал зөрчилгүй ажилласан. | 2024.04.05<br>2024.06.10 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 2 | Засаг даргын А/55 дугаар захирамж | Төлөвлөсөн хугацаанд ажлын гүйцэтгэлийг хангах | | | Засаг даргын А/55 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон Хөдөө булан, Дайргын голын тариалангийн талбай, талбайн ойр орчмын 1336.1 га талбайд бактержуулсан будаагаар оготно устгалын ажлыг тариаланчидтай хамтран зохион байгуулсан. | 2024.04.05<br>2024.05.10 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

118

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Арвайхээр сумын бэлчээрийн хөнөөлт мэрэгч ихээр тархсан талбайд микробиологийн аргаар тэмцэхээр сумын малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 1,53тн, аймгийн ХХААГ-аас 2ттн нийт 3,53тн бактержуулсан будааг Шим ХХК-тай гэрээ байгуулан мэрэгч устгах ажлыг зохион байгуулж нийт 45 малчин өрх хамтарч ажилласан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлж буй мэдээллийн системийн сургалтад хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн байна. | Сургалтад хамрагдсан тоо | - | Мал аж ахуйн салбарын мэдлэг сайжирсан байна. | Хөдөө аж ахуйн яам, аймгийн Хөдөө аж ахуйн газраас Архангай, Өвөрхангай аймгийн Мал аж ахуйн салбарын мэргэжилтэнгүүдийг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэл, хөгжүүлэлттэй холбогдон "Малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх" сэдэвт орон нутийн мэргэжилтнүүдиийг чадавхжуулах сургалтыг 10 дугаар сарын 4-ны өдөр зохион байгуулж сертфикат олгосон. | 2024.10.04 | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |
| 2. | Үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах | Дунд шатны мэдлэгтэй болох | Монгол бичгийн анхан шатны | Албан бичгийг хосолсон хэлбэрээр | Байгууллагаас албан хаагчдын дунд 3 сард зохион байгуулсан монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. | II улиралд | Төлөвлөсөн үр дүнд хүрсэн 100 хувь |

179

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдлэгт эй. | төлөвлөж сурсан байх | Албан хэрэгцээнд ашигладаг суурин компьютерт монгол бичгийн үсгийн фондыг суулган цаашид ашиглах ур чадвараа нэмэгдүүлэх түвшинд ажиллаж байна. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

МАЛ АЖ АХУЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................ (Г.ЭНХ-ОЮУН) 2024.11.22

180